



**БУЛГАН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2017 оны 11 сарын 02 өдөр

Дугаар 124

Булган

**Дуудлага худалдаа зохион  
байгуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 132 дугаар тогтоол, 2014 оны 17-дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээд үндсэн хөрөнгө олж авах, худалдах, шилжүүлэх, актлах журам”-ыг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Дуудлага худалдаагаар борлуулах тээврийн хэрэгсэлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Дуудлага худалдааг 2017 оны 11 дугаар сарын 13-ны өдрийн 11 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд явуулсугай.

Гурав. Дуудлага худалдааны орлогыг 100 хувь аймгийн хөрөнгө борлуулсны орлогын дансанд төвлөрүүлсүгэй.

Дөрөв. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавин, хавсралтанд заагдсан тээврийн хэрэгсэлүүдийг аймгийн төвд татан төвлөрүүлж, дуудлага худалдааг зохион байгуулахыг Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Батжаргал/-д үүрэг болгосугай.

ДАРГА



М.ОЮУНБАТ

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн  
Хурлын 2017 оны 44 дугаар  
тогтоолын хавсралт



Дуудлага худалдаагаар худалдан борлуулах тээврийн хэрэгсэл

/Төгрөгөөр/

№	Сум, байгуулага	Хөрөнгийн нэр төрөл	Улсын дугаар	Дуудах анхны үнэ
1	Баян-агт сум ЗДТГ	УАЗ-315122	16-38 БУА	490.000
	<b>Хөрөнгийн дүн</b>			<b>490.000</b>